

НИСЛЭГИЙН ЦАГ УУРЫН ТӨВИЙН
2019 ОНЫ 02 ДУГААР САРД ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2019.03.06

Мэдээлэл үйлчилгээний талаар:

2019 оны 2 дугаар сард “Чингис хаан” олон улсын нисэх буудал орчмын богино хугацааны урьдчилсан мэдээ /TAF/ мэдээ 185, урт хугацааны урьдчилсан мэдээ 112, районы урьдчилсан мэдээ 182, угталтын урьдчилсан мэдээ 139, өндрийн салхины урьдчилсан мэдээ 224, аэродромын урьдчилсан мэдээ 56, SIGMET мэдээ 27, Тосонцэнгэл нисэх буудал орчмын богино хугацааны TAF 61, хөөрөлтийн урьдчилсан мэдээ 172, Ханбумбат нисэх буудлын TAF 142, Овоот нисэх буудлын TAF 20, бусад нисэх буудлын урьдчилсан мэдээ 14 удаа тус тус гаргаж, олон улсын 530, орон нутгийн 404, онцгой ба тусгай үүргийн 5 нислэгийг 234 чиглэлийн урьдчилсан мэдээ болон цаг агаарын төрөл бүрийн мэдээ мэдээллээр үйлчилсэн байна. Хэрэглэгчдийн хүсэлтийн дагуу цаг агаарын зөвлөгөөг утсаар болон цахимаар өгч байна. Төв орон нутгийн 4564 бодит мэдээ, 1651 урьдчилсан мэдээг хүлээн авч дамжуулсан байна. 2 сард сард Европын дунд хугацааны тоон прогнозын зураг, Япон, Солонгосын прогноз зураг, болон өндрийн цаг агаарын зураг /850гПа, 700гПа, 500гПа, 300 гПа, ОТ 1000:500/, газрын цаг агаарын зураг, орчны цаг агаарын бодит зураг, онцгой үзэгдлийн зураг, олон улсын нислэгт зориулж салхи температурын орны зураг, FY-2C болон Himawaricast японы хиймэл дагуулын үүлний зураг тус тус хүлээн авч мэдээ зохиолт болон нислэгийн үйлчилгээний ажилд ашигласан. WAFS бүтээгдэхүүнүүд хэвийн.

36 цагийн урьдчилалтай тоон загварын үр дүнг боловсруулж, 7 хоногийн төлөв гаргахад зориулж 168 цагийн урьдчилалтай тоон загварын үр дүн, стандарт өндрүүдийн салхи температурын орны зургуудыг тус тус урьдчилсан мэдээ зохиолт, нислэгийн үйлчилгээнд ашиглаж байна.

Чингис хаан ОУНБ орчмын урьдчилсан мэдээний таарц, нислэгийн саатал:

Энэ сард нийт цаг агаараас шалтгаалсан нислэгийн 10 саатал гарсан. Үүнд: таарсан 10, таараагүй урьдчилсан мэдээ 0, /2018 оны 2 сард нийт 21 саатал гарсан, таарсан 17, таараагүй 4/

Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад богино хугацааны урьдчилсан мэдээний таарц 2.6 хувиар, урт хугацааны урьдчилсан мэдээний дундаж таарц 4.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

02 дугаар сарын 13-20-ны өдрүүдэд ИНЕГ-ын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албанаас томилогдсон ажлын хэсэг ИНД-174-ийн “Нисэхийн цаг уурын үйлчилгээ эрхлэх байгууллагыг гэрчилгээжүүлэх” дүрмийн дагуу олгогдсон гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгах төлөвлөгөөт үзлэг шалгалтыг явуулсан.

Ажлын хэсгийнхэн өмнөх шалгалтаар өгөгдсөн үүрэг даалгаврын хүрээнд хийсэн ажлууд, төлөвлөгөөний биелэлт, нислэгийн аюулгүй ажиллагааг хангахтай холбоотой тоног төхөөрөмжийн бэлэн байдал, техникийн баримт бичгийн хөтлөлт, цаг агаараас шалтгаалсан нислэгийн саатал зөрчлийг бууруулах талаар авсан арга хэмжээ, мэдээ зохиолт, дамжуулалт, бүтээгдэхүүн ажил үйлчилгээ, хамтран ажиллах гэрээ, түүний хэрэгжилт, мөрдөгдөж буй заавар журмын хэрэгжилтийг шалгаж гэрчилгээ олголоо.

УЦУОСМХ-нд боловсруулдаг Японы HIMAWARI, Хятадын FY4 хиймэл дагуулуудын үүлний зурагт Улаанбаатараас нислэг үйлдэгддэг олон улсын 17 нисэх буудлуудын байршлын мэдээлэл оруулж тэмдэглүүлсэн.

Нислэгийн цаг уурын үйлчилгээг шинэчлэн сайжруулах Дэлхийн цаг уурын байгууллага, БНСУ-ын цаг уурын байгууллагын хамтарсан төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд ДЦУБ, БНСУ-ын Цаг уурын байгууллагын судалгааны баг 2019 оны 02 сарын 18-22-ны өдрүүдэд тус төвийн үйл ажиллагаа, цаг уурын үйлчилгээ, мэдээлэл солилцоо, тоног төхөөрөмж зэргийг судалсан. Уулзалтад Дэлхийн цаг уурын байгууллага, БНСУ-ын Цаг уурын газар, Солонгосын нислэгийн цаг уурын агентлагийн төлөөлөгч, Цаг уур, орчны шинжилгээний газрын мэргэжилтнүүд, ИНЕГ-ын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны цаг уурын байцаагч, Нислэгийн цаг уурын төвийн удирдлагууд оролцсон.

Сургалт дадлага, хурал, семинар:

Нислэгийн цаг уурын төвөөс 2 жил тутамд зохион байгуулдаг Иргэний агаарын тээврийн нислэгт цаг уурын үйлчилгээ үзүүлэх шалгуур үзүүлэлтийг хангасан инженер, техникчдэд зориулсан давтан сургалтыг 2019 оны 2 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн 5 хоногийн хугацаатай зохион байгуулсан. .

Сургалтаар үйл ажиллагаанд мөрдөгддөг заавар, журамд орсон нэмэлт өөрчлөлтүүд, онолын болон технологийн бататгах хичээл, дадлага явуулж ЦУОШГ-ын даргын тушаалаар нислэгт цаг агаарын бодит ажиглалтын мэдээгээр үйлчлэх “Мэргэшлийн үнэмлэх” олголоо.

02 дугаар сарын 19-нд ИНЕГ-ын Аэродромын албаны хүсэлтээр аэродромын инженерүүдэд METAR, TAF сэдвээр 2 цагийн сургалт сургалт явуулсан.

02 дугаар сарын 21, 28, 03 сарын 01-ний өдрүүдэд Оюутолгойн дрон хариуцсан ажилтнуудад цаг уурын 3 цагийн сургалт явуулсан.

02 дугаар сарын 22-нд шинээр Монголиан эйрвэйс карго ХХК-тай цаг агаарын мэдээгээр үйлчлэх, ашиглах талаар хамтран ажиллах гэрээ 1 жилийн хугацаатай байгуулсан. 2 сарын 28-нд Нислэгийн цаг уурын төв болон ЭЙ СИ ЭЙЧ СЕРВИСЕС ХХК хооронд цаг агаарын мэдээгээр үйлчлэх, ашиглах талаар хамтран ажиллах гэрээг дүгнэх сунгах уулзалт ЦУОШГ-т зохион байгуулж гэрээг протоколоор 1 жилийн хугацаатай сунгасан.

Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэх бэлтгэл ажлын хүрээнд ажлын байрны шинжилгээний асуулга хэлтсийн нийт албан хаагчдаас авч байна.

Дүгнэлт:

Нислэгийн цаг уурын төвийн 2019 оны 01 дүгээр сарын шинжилгээ, мэдээлэл үйлчилгээ, тоног төхөөрөмжийн ажиллагаа “Хэвийн” явагдсан.

Нислэгийн цаг уурын төв